

**МОНГОЛЧУУДЫН “НЯЛХСЫГ УХИЯАХ” ЗАН ҮЙЛ:
БОРЖГИН ТАЙЖ НАРЫН ГЭРИЙН АМАН УЛАМЖЛАЛ**

Г.Нандинбилиг

Товч агуулга: Монгол ёсонд хүмүүний төрөх мэндлэхээс эхлээд насан эцэслэх хүртэлх нэгэн насны амьдралын мөчлөг үеүдэд тодорхой зан үйлийг ёслон гүйцэтгэж иржээ. Үүний анхных нь шинэ хүүхэд төрж мэндлэхэд хийдэг “нялхын угаалга (ухиал)”-ын ёслол юм. Бид энэ өгүүллээрээ хуучин Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны гол баг, одоогийн Хөвсгөл аймгийн Галт сумын Зүрх багаас уугуул гаралтай “Тайж нар” овгийнхны хүүхдийн ухияалын гэрийн зан үйлийн уламжлалын талаар мэдээлсэн настны аман хууч ярианд¹ тулгуурлан боржгин тайж нарын хүүхдэдээ нэр өгөх ёс буюу “Нялхсыг ухияах” зан үйлийг тодруулахыг зорилоо. Энэхүү хүүхдийн ухияалын ёслол нь эртний уламжлалаасаа нэлээд хувирч зарим зүйлс нь гээгдсэн ч язгуур санаа нь хадгалагдаж байгаа нь тус зан үйлийг түүхэн сурвалжийн мэдээ болон өмнө судлагдсан хүүхдийн мялаалгын зан үйлийн уламжлал, монголчуудын хүүхдийн овооны тахилгын зан үйл, урьд өмнө хэвлэгдсэн уран зохиол, аман зохиолын жишээ баримтаар нөхвөрлөн судлах боломжийг олгож байна.

Түлхүүр үг: *Аман уламжлал, нялхсын ухияал (угаал), нэр өгөх, зан үйл, тэнгэр нар, Милаагууд*

Монгол ёсонд хүмүүний төрөх мэндлэхээс эхлээд насан эцэслэх хүртэлх нэгэн насны амьдралын мөчлөг үеүдэд тодорхой зан үйлийг ёслон гүйцэтгэж иржээ. Халх монголчууд “Монгол хүн гурван хуримтай, гурван гүрэмтэй” гэж хэлдэг. Энэхүү онцлон буй гурван хуримыг нэрлэвэл, хүүхэд төрж мэндлэхэд өвөө, эмээ (аав, ээж)-ээс хийж өгөх ухияалын хурим, нас биед хүрч ураг барилдахад эцэг эхээс нь хийж өгөх ураг хурим, насан эцэслэхэд үр хүүхдүүдээс ёслон гүйцэтгэх оршуулгын хурим гурвыг хэлж байна. Хурим хэмээхийн учир нь гэр бүл, ураг удмаараа хуран цуглаж, тэнгэр дээдсээ дуудан, ураг удмын бүртгэлд нэгэн шинэ хүн, нэгэн шинэ гэр бүл нэмэгдэж буйг зарлаж, тэнгэр болоод удмын өвөг дээдэс болоод садан төрөлдөө таниулж буй, эсвэл хэн нэгнээ өвөг дээдэст нь хүлээлгэн өгч буйгаа ёслон тэмдэглэж буй утгатай тусгай зан үйл бөгөөд энэ зан үйлийн үед ямагт “хурим”² нэрт цагаан идээнийг дээжлэн амсаж цагаалдаг ёстой холбоотой байна.

Хүмүүний төрөх мэндлэх үед эцэг эхээс ёслон гүйцэтгэх ёстой зан үйл нь нялхсыг ухияах (угаах) зан үйл юм. Энэ нь шинээр мэндэлсэн хүүхдийг Милаан тэнгэрт таниулах зорилготой эртний ёс “Милаагуудын хурим”-аас үүдэлтэй. Энэ ёслол нь нялхсыг эхээс төрөөд гурав хоносны дараа шаантны шөлөөр ухияан, шинэ хүүхдийг мялааж, шинэ хүүхдэд нэр соёрхох зорилготой ёслол юм.

Түүхэн эх сурвалжийн мэдээллээс үзэхэд монголын язгуурын заншилд ийнхүү нялх хүүхдийн төрөхөд мялаадаг энэхүү зан үйлийг “Мялаагуудын хурим” гэдэг тухай, Чингис

¹ Лханаагийн Сосор, 75 настай, морь жилтэй, тайж нарын бэр. 1992 оны 12 сарын 10-нд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын төвд Г.Нандинбилиг тэмдэглэж авав.

² “Хурим” хэмээх дээж идээ нь цагаан будаатай буцалгасан аарц байна.

хааныг мэндлэхэд ч энэ ёсыг хийсэн тухай, тэр өдрийг хожим “Өвлийн улирлын тасман хурим” гэж монголчуудын “Дөрвөн цагийн хурим”-ын нэгэн болгож тэмдэглэн, их хурим хийдэг болсон тухай мэдээлсэн байдаг. Энэ тухай Галданы “Эрдэнийн эрих”-д: “Арван сарын шинийн гурванд Богд Чингис хааны гэгээн бие гийснээ ухияагсан мялаагуудын өдөр” гэж, “Эрдэнэ тунамал нэрт сударт: “Дээд төрөлхтөн Жүнхэн хатнаас нэгэн хөвүүн эсэнлэсэнд дээш хаан тэргүүтэн хамаг их улс баясгалант мялаагуудын хурим хийж, тэр хөвүүнийг Будашири хэмээн нэрлэж” гэхчлэн өгүүлсэн байдаг бол “Арван буянт номын цагаан түүх”-д “Өвлийн дунд хулгана сарын хугас шинэд (7-8) Чингис хаан мялаагуудыг хийснээр өвлийн тасам талбихын хуримыг тэр өдөр үйлдэх болов” (Iiu Jin Suwe, 1981:88) гэж тэмдэглэжээ. Ямааны хөдсийг зүсэж тасам болгон нялх хүүхдийн хүйс болон өлгийг боодог байснаас “тасман хурим” гэж бас нэрлэж байжээ (Дулам, Нандинбилиг, 2007:108).

Буриад зоны уламжлалт заншил ёсоор шинэ мэндлэгсдэд хамаатай “түрэлгэ”, “билага”, “үлгэдэ оруулха” гэсэн цувраа гурван зан үйл буй билээ. “Түрэлгэ” гэдэг нь шинээр мэндэлсэн хүүхдийг үр шимийн эзэн Заяан Сагаан тэнгэрт даатгах анхны тайлга тахилга, “билага” гэдэг нь өлгийдөх манцуйлах хоёрдогч зан үйл бөгөөд энэ хоёр бол бөө удган оролцдоггүй, ер бөө мөргөлөөс өмнөх үеийн зан үйл, “үлгэдэ оруулха” гэдэг нь шинэ мэндлэгчид зориулан гаргасан хонь малын далны яс болон шагайт чөмгийг сахиус болгон зүүсэн өлгийд нялхсыг өлгийдөх гуравдагч зан үйл бөгөөд бөөгийн үйлддэг зан үйл болно (Манжигеев, 1978:79). Энд өгүүлэн бүхүй цогц зан үйл, “билага” хэмээх нэр нь эртний милаагуудын хуримын анхдагч хэлбэрийн зүйл мөн бололтой. Харин халх уламжлалын тухайд нарийвчлан судалсан зүйл хомс байна.

Бид энэ өгүүллээрээ хуучин Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны гол баг, одоогийн Хөвсгөл аймгийн Галт сумын Зүрх багаас уугуул гаралтай “Тайж нар” овгийнхны хүүхдийн ухияалын гэрийн зан үйлийн уламжлал болон тус зан үйлийн талаар дэлгэрэнгүй мэдээлсэн настны аман хууч ярианд³ тулгуурлан боржгин тайж нарын хүүхдэдээ нэр өгөх ёс буюу “Нялхсыг ухияах” зан үйлийг тодруулахыг зорилоо.

Энэхүү хүүхдийн ухияалын ёслол нь эртний уламжлалаасаа нэлээд хувирч зарим зүйлс нь гээгдсэн ч язгуур санаа нь хадгалагдаж байгаа нь тус зан үйлийг судалж, түүхэн сурвалжийн мэдээ болон буриадын хүүхдийн мялаалгын зан үйлийн уламжлал, монголчуудын хүүхдийн овооны тахилгын зан үйл, урьд өмнө хэвлэгдэж, олны хүртээл болсон жишээ баримт зэргээс нөхвөрлөн тодруулах боломжтой байна.

Хүүхдийн ухияалын бэлтгэл:

Хүүхэд төрсний дараа гурав дахь хоног дээр эхийн бие хөнгөрч цэвэршээд өндийх болоход хүүхдийн авга талаас бэлтгэж, хүүхдийн ухияалын хурим хийнээ. Хуримыг эмэг нь буцалганаа, их саванд дүүрэн, тахилын өмнө тавинаа. Таваг цагаанаар заснаа.

Хүүхдийн ухияалд бүстэй хүүхэд бол баруун шаант, бүсгүй хүүхэд бол зүүн шаантыг чананаа. Шаантны хонь авгын сүргээс байна аа, хүүхдийн чихээр хатгахгүй ээ. Нагацын сүргээс байнаа хүүхдийн ам гэмтэхгүй ээ, хөнгөн байнаа.

Шаантны хонийг цагаан эсгий дээр төхөөрнө өө. Өвчүү түшсэн хүн:

- Манцуйлж байгаа манцгар чинь

Мяндсан ухаантай болог

Майлж байгаа хонь чинь

Мянга түм хүрэг гэж хэлнээ.

Хонь төхөөрсөн хүн ерөөл тогтооноо

- Ерөөл тогтог гэж хэлж тогтооно⁴.

³ Лханаагийн Сосор, 75 настай, морь жилтэй, тайж нарын бэр. 1992 оны 12 сарын 10-нд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын төвд Г.Нандинбилиг тэмдэглэж авав.

⁴ Мөн тэнд.

Хүүхдийн ухияалын ёслол:

Аман сурвалжийн мэдээллээс үзэхэд хүүхдийн ухияалын ёслол нь заллага, ариулга, сан, сацал, даллага, хурайлга, мялаалга, соёрхол, даатгал, залбирал гэсэн хэсгүүдээс бүрдэж байна. Үүнд:

Заллага. Хүүхдийн ухияалын хуримд хүүхдийн авга, нагац, хүүхдүүдийг зална, шинэ төрсөн хүнтэй ивээл жилтэй хүүхдийг эцэг зална, хөөрөгтэй мордоно. Мөн хот айлын арван гурав хүрээгүй багачуулыг зална. Багачуул багадаа долоо байна, саахалтаас нэмж зална. Авга нагац ах эгч нар заллагагүй ирнэ. Сүүлдэж ирээд лам залдаг болжээ.

Ариулга. Хүүхдийн хуримд ирсэн авга нагац нар насны эрэмбээр гэрийн баруун талаар сууна, залсан багачуулыг томчуулын өмнүүр суулгана. Ивээл жилтэй хүүхдээр арц унгасгана (лам залсан бол лам арц ариулгаа хийнэ) зочид авчирсан сахиус наадгай, бэлгийн зүйлсээ нар зөвшөөр гурав эргүүлж ариулна аа.

Сан. Арц ариулсны дараа лам “сан” уншихад бүгдээр даган баяснаа. (Хуучиндаа бол “Долоон өвгөн одны тахилгын сан” гэж уншина, ивээл жилтэй хүүгээр эхэлсэн болоод, эцэг нь уншихна. Тэнгэрээр эхэлж газар эхээ дуудна аа, долоон одондоо сацлаа дуулгана, хэний ямар угсааны хэн гэж айл ямар тахил өргөж байгаагаа хэлнээ, ийм жилтэй, тийм үр гээд таниулна. Би сан унших биш, сонсоно, одоо мартаж. Сударт юу гэж вэ, хараад уншинаа.⁵). Энд ярьж буй “Долоон өвгөн одны судрын санааг Хэрлэн Баян улааны хадны хонгилоос олдсон “Долоон өвгөний судар” –ын агуулгатай харьцуулахад төсөөтэй байна. мөн хүүхдийн овооны тахилгад Долоон бурхан одны судар уншдаг гэсэн мэдээ бий. Иймээс сангийн судрын эхний хэсгийг сийрүүлбэл: “Тэнгэрийн тэнгэр бурхан номлосон Долоон өвгөн нэрт одноор амин нас урт болох нэрт ном бичиг нэгэн зүйл... “ гэж эхэлж буй.

“ДОЛООН БУРХАН” ОДНЫ СУДАР

Хүй ихт 99 тэнгэр

Хөвчин ихт 77 Этүгэн эхээс үүдэгсэн

Ерэн түмний одны дундаас

Долоон өвгөн нэрт одноо

9 зул, 9 хүж, жимс, цай, архи,

Халзан цагаан хонь, 9 сацал бэлтгэж,

Ариун тахил тахин мөргөнөм.

Алтан одон гэрэлт,

Алман саран туяат

Арван түмэн одны дундаас

Долоон өвгөн нэрт одноо

Ариун тахил тахинам.

...Хутаг хишиг энэ өдөр энд орштугай

Ийм жилт, тийм омогт өчүүхэн хүмүүн гарахыг заяах болтугай.

...Өвчүүнээс нь түшиж

Эрийн зэрэгт хүргэ гэж

Хүзүүнээс нь түшиж

Хүний зэрэгт хүргэ гэж

Ариун тахил тахинам...

Хуруй хуруй хуруй (Дамдинсүрэн, 1959:133)

⁵ Лханаагийн Сосор, 75 настай, морь жилтэй, тайж нарын бэр. 1992 оны 12 сарын 10-нд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын төвд Г.Нандинбилиг тэмдэглэж авав.

Сацал. “Сан уншиж эхлэхэд эмэг (хөгшин ээж) гарч, сацал өргөнөө. “Сацал өргөхдөө хан мөнх тэнгэр, хан газар усан гэж эхэлнээ, дараа нь Заяан тэнгэрт, наранд, долоон одонд гээд өргөнө өө. Дараа нь Хангай хан, Хэнтий ханд өргөнө өө, уугуул байгуул (суугуул) нутагтаа өргөнө өө. Тэгээд ес болнуу. Хангай дэлхийд гэж хамаагүй хурааж болохгүй ээ, заавал хан цолыг дуудна аа. Дээд бригадынхан Отгонтэнгэрээ бас хэлнээ. Дараа нь сарын сайныг, өдрийн өлзийтэй хэлнэ ээ, сая төгс сацсан болно оо. Ирэх нь ирнэ ээ, байсан нь баясна аа. Сацаж бараад сая ээл заяаг гуйнаа. Сайн зүгийн тэнгэрээс заяа гуйнаа аа. Сайн зүгийн тэнгэр баруунд байна аа. Өмнө зүгийн тэнгэрээс өлзий хутаг хишиг гуйна аа. Гуйлаа гэхгүй ээ, орштугай гэнэ ээ. Орших гэж ээжийн чинь нэр ээ, сацалд яахав дээ хэлж болно оо, хэлэхгүй ээ гэвэл болтугай гэж хэлнэ ээ. Дараа нь даллага авнаа”⁶.

Даллага, хурайлга. Даллагыг эцэг эх нь авна аа. Эцэг нь галдаа өөх тос, таван өнгө торго, зай (алт, мөнгө, зэс, оюу гэхчлэн есөн эрдэнийн зүйлээс зорж бэлтгэсэн нэгэн зүйл өргөл) өргөнө өө. Эх нь даллагын сумаа барьж, үр хүүхдийнхээ хишиг буяныг хурайлан даллаж, даллага авна аа. Даллага эхлэхэд хүүхдийн угаалгад ирсэн хүмүүс бэлтгэж ирсэн сахиус бол сахиусаа, одоогоор бол авчирсан бол тоглоом наадмаа, баривч, бойтог юу авчирсан түүнээ өвөр дээрээ гаргаж тавин даллага авна аа. Хүү бол наран тээнгэ, хүүхэн бол саран тээнгэ оёж ирнэ ээ... Даллагын үгийг бас хэлнэ үү. Нар, сар, одны хөвүүн гэж буян хишгийг даллана аа. Тоогоор даллагаа авна аа. Гурван цагийн бурхны буян хишгийг даллана аа, дөрвөн зүгийн тэнгэрийн буян хишгийг даллана аа, таван зүсгийн малын буян хишгийг даллана аа, зургаад юмгүй ээ, долоон одны буян хишгийг даллана аа, найман цагаан бор адууны буян хишгийг даллана аа, есөн зүйлийн эрдэнийн буян хишгийг даллана аа. Бүгдийг сайхан холбоод хэлнэ ээ. Дараа нь амны хишгийн даллага авна аа. Ам цагаан хулганын буян хишгийг гэж даллана аа, аянд унах хүлгийн буян хишгийг даллана аа, анд сайн нөхрийн буян хишгийг даллана аа, хүү бол авд дагуулах нохойн буян хишгийг даллана аа, үр зөөр, хань ижлийг ч даллана аа, сайн бүхнийг даллана аа, хурайлна аа. Урт насны хутгийг умар зүгийн тэнгэрээс даллана аа, хурайлна аа. Өмч хувийн өлзий хишгийг өмнө зүгийн тэнгэрээс даллана аа, бас хурайлна аа. Амин насан урт бол гэж даллана аа, бас хурайлна аа. Үр зөөр өнөр бол, өмсөх эдлэх дутуугүй бол гээд даллана аа, хурайлна аа, Буян хишиг иртүгэй гээд хурайлна аа, хуран ирүүл, тогтоож хайрла гээд хурайлна аа, тоолоод долоо болгож хурайлна аа. Хурайлгаар хишиг буяныг тогтооно оо”⁷. Аман ярианаас үзэхэд зан үйлийн шүлгийн санаа зорилго нь хадгалагдаж байгаа ч шүлэглэсэн хэлбэр нь алдагдаж, хэсэг бусад шинжтэй болсны дээр ивээл жилтэй хүүхдээр сан тавиулдаг байснаа лам залдаг болсон, гэрийн эзэн сангийн судраа уншчихдаг байснаа ламаар уншуулдаг болсон зэргээр бурхны шашны нөлөө орж хувирсан тал байгаа ч гол ёслолууд нь саяхныг болтол хадгалагдсаар байсан байна.

Мялаалга. Долоон одны сан уншиж, даллага авсны дараа эхлээд эцгийн сийлсэн өлгийг мялаана аа. Одоотой адилгүй, модон өлгий сийлнэ ээ. Гууль эсгэж, есөн нүх цохино оо. Эцэг бас үнэг хайчилна аа. Хайчилсан эсгий үнэгээ есөн нүхтэйгээ зүүж өгнө өө. Дараа нь шинэ хүнээ шаантын шөлөөрөө угааж мялаана аа. Зулай, магнайгаас эхлээд эх нь угаана аа. Хүүхдээ угааж бараад өлгийднө өө. Эх нь хүүхэддээ хурим дээжилж мялаагаад, амссан болгоод, хүүхдийнхээ өлгийн бүсэнд шаант чөмгийг хавчуулаад, “Нэр хайрла” гээд эцэгт нь өгнө өө. Эцэг нь хоймор суусан өөрийн эцэгтээ “Нэр хайрла” гээд хүүгээ золгуулна аа. Эцэг үгүй бол настан авгадаа золгуулна аа. Нэр хайрлах авга настан үгүй бол хүүхдийн эцэг өөрөө нэр хайрлана аа. Хүүхдэд нэр хайрлахдаа удмын түүхээ барьж, нэр хэлнэ ээ. Бүстэй хүүхдийн бол баруун чихэнд, бүсгүй хүүхдийн бол зүүн чихэнд нэрийг хэлнэ ээ. Нэр хэлээд тулганаас хөө авч, шинэ хүнийхээ магнайг зурвас хөөднө өө. Энэ нь Заяан тэнгэрт таниулж байнаа. Өвөг дээдэс бас танина аа. Нэр хайрлах хүн орогч насаа бодно оо, долоо орсон хүн өөрийн насыг

⁶ Лханаагийн Сосор, 75 настай, морь жилтэй, тайж нарын бэр. 1992 оны 12 сарын 10-нд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын төвд Г.Нандинбилиг тэмдэглэж авав.

⁷ Лханаагийн Сосор, 75 настай, морь жилтэй, тайж нарын бэр. 1992 оны 12 сарын 10-нд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын төвд Г.Нандинбилиг тэмдэглэж авав.

аваарай гэнэ ээ. Долоо ороогүй бол удмынхаа аль өндөр насыг хэлээд нас соёрхно оо. Хүүхэд нагацын гал дээр төрсөн бол нагац нь нэр хайрлаж таниулна аа, үнэгийг бас нагац хайчилна аа. Нагацын эсгий үнэг гэж үгтэй юм аа”.

Хүүхдийн ухияалын энэ уламжлалаас үзэхэд нялх хүүхдийн магнайг бор халзан туулай болгож хөөдөх ёс нь Заяан тэнгэр болоод удмын өвөг дээдэст таниулж нэг ёсондоо тэмдэг тавьж бүртгүүлж байгаа утгатай байна. Үүнээс хойш хүүхдийг Заяан тэнгэр нь харж сахиж байдаг учиртай байна. Хүүхдийн ухияалын энэхүү уламжлал нь хорь буриад зоны дунд сая болтол уламжилсан “Милаангууд” буюу “Тоонот тайх” ёслолтой хүүхдийн магнайг хөөдөж таниулж байгаагаараа төстэй байгаа бөгөөд аль аль нь эрт цагийн Милаан тэнгэрийг тайх тахих уламжлалын бүрэлдэхүүн хэсэг байсан бололтой юм.

Буриад уламжлалд гэрийн баруун урд ханан талд шинэ төрсөн хүүхэдтэй ивээл жилтэй хоёр залуу эр, наад талд нь мөн ивээл жилтэй хоёр эм хүн сууж, хүүхдийн унасан газар дээр мод жиргэж, тохой хэрийн өндөр тоонотой урц босгоно. “Дээврийг нь талла” гэхэд урцны гадуур нь сэмжээр нэг, сэрс хадгаар нэг ороон, улаан утсаар оосор бүслүүр хийнэ. Тэгээд урцандаа алт, торгоны үртэс, есөн эрдэнийн зай, үгүй бол шүр, мөнгө үрж, гурван эрдэнэ орлуулж, бас арц хүж хийдэг. Тэгсний сүүлээр урцандаа гал оруулаад, тостой шөлнөөс дөрвүүл балгаад тургиад байх бөгөөд тэр нь сэмжний өөхтэй авалцаж, гэрийн дээвэр тоононд тулсан их гал болдог байна. Тэг тэгсээр шатсан урц унахдаа хэн рүү нь хандаж ойчвол тэр хүнийх нь үр зөөртэй болох нь гэж их бэлгэшээдэг. Урцыг унангуут хоёр залуу эрийн нэг нь долоовор хуруугаар хүүхдийнхээ цохноос хамрын үзүүр шувтартал хөөдөж орхиод “хар халзан туулай бай” гэж хэлдэг сэнж. Энэ нь хүүхдийг номхон дөлгөөн бай гэсэн бэлгэдэл утгатай гэнэ. Цугласан эмэгтэйчүүд эхнэр дээлтэй, эрчүүд энгэртэй дээлтэй байх ёстой бөгөөд тостой хөөг хуруугаар өлгөж аваад нүүр нүүрээ тарлан эрээн болтол хөөдөлцөх домтой. Сүүлд нь юмыг зайлуулан цэвэрлээд, ширдэг дэвсээд хоёр залууг барилдуулна. Мөн тэр газар сугацаа тулахаар гүн их нүх малтаад, шар цагаан будаа, есөн эрдэнийн зай сацаад, ихэсийг (хэгээг) цагаан бөсөөр ороож, эсгий уутанд хийгээд газар дор шингээж, хөх чулуугаар дарж, эргүүлэн тэгшилж орхино. “Хүй дарсан хөх чулуу” гэдэг нь тэр аж. Энэ ёслолын үеэр Милаан тэнгэрийг хиншүүгээр тахиж, төрсөн орон дэлхийг баясгаж, амин насыг батжуулж жинсрэгдэж, лусыг ариутгаж байгаа учиртай юмсанжээ (Дулам, 2002:258-259).

Мөн цаашилбал монголчуудын энэхүү балчир хүүхдийн магнайг хөөдөж бор халзан туулай болгох ёс нь хожим бурхны шашны нөлөөг хүртэж, Милаан тэнгэрийн оронд Лхам бурхны дүртэй холбогдож хувирсан байдаг. Домогт өгүүлэхээр, “Эрт урьд цагт ганц хүүтэй эр эм хоёр нэг давааны өвөрт байж гэнэ. Ганц хүүг нь хоёр чөтгөр авах санаатай, нэг нь үдшийн харуй бүрийгээр очиж хооронд хэрэлдүүлээд, нөгөөх нь давааны ард хонхор дотор отож байхаар болж гэнэ. Хэлсэн ёсоор үдшийн бүрийгээр эр эм хоёр хэрэлдэж цуугилдаад салах сарнихдаа хүрч эм нь ганц хүүгээ хамрыг нь хөөдөж аваад давааны ард байдаг төрхөмдөө буцахаар явж гэнэ. Болзсон ёсоор нөгөө чөтгөр нь давааны арын хонхорт очоод тэсэж ядаж байтал нэг бор халзан туулай хөлөглөсөн хагархай хар тогоо үүрсэн доголон цагаан дар эх хажуугаар нь өнгөрөхөд нөгөө чөтгөр айхын ихээр айж хонхор дотроо навтайсаар хоцорч гэнэ. Гэтэл нөгөө чөтгөр нь араас нь хүрч ирээд за яав, юу болов хүүхдийг нь авч чадав уу гэсэн хэн ч юу ч өнгөрсөнгүй, харин бор халзан туулай хөлөглөсөн, хагархай хар тогоо үүрсэн доголон цагаан дар эх хажуугаар гараад явахлаар золтой ухаан сүнс зайлчихсангүй гэж гэнэ. Хоёр чөтгөр учрыг олохгүй гайхахын ихээр гайхаад хоцорч. Тэгсэн чинь нөгөө хүүхэн үдшийн бүрийгээр хүүхдээ тэврээд явахдаа Цагаан Дар эхийн уншлагыг алдаа мадагтайхан уншиж явсан гэнэ. Тэхлээр хамраа хөөдсөн хүүхэд нь бор халзан туулай болж үзэгдээд, толгойтой үс нь хагархай хар тогоо болж харагдаад, хүүхэн өөрөө доголон цагаан Дар эх болж мэдэгдээд байсан юм гэнэ лээ”⁸.

⁸ Баянхонгор аймгийн Баянбулаг сумын харьяат, 66 настай эмэгтэй Бавуугийн Должингоос 1991 оны 8 сарын 02 –нд С.Дулам Чингэлтэйн зусланд бичиж авав.

Монголчуудын нялх хүүхдийн магнайг хөөдөж, бор халзан туулай болгох ёс уламжлалыг халх болон буриадын жишээн дээр харьцуулж үзвэл, энэ нь эртний уламжлалдаа Милаан тэнгэрт таниулах ёс байснаа буриад уламжлалдаа “Тоонот тайх ёслол” болж, халх уламжлалдаа Заяан тэнгэр, долоон одонд таниулах ёс болж багахан хувирсан байх төдийгүй бурхны шашин хүчтэй дэлгэрсэн зарим нутагт тэнгэрийн оронд Лхам бурхны дүртэй холбогдож хувирсан замнал харагдаж байна.

Даатгал, залбирал. “Хүүхдэд нэр хайрласны дараа амин насыг нь Заяан тэнгэрт даатгана аа. Төрсөн жил гарагаар нь долоон одонд нь даатгана аа. Амин насыг нь аргамж гэж хэлнэ ээ. Хан гэх ханиадгүй, тон гэх томуугүй, харж манаж бай гэж даатгана аа. Бүгдээр амь амины даатгалаа амлаж залбирна аа.”

Аман сурвалжийн мэдээнд даатгалын үг хэллэгийн талаар мэдээлэл хомс байгаа тул аман зохиолын сан хөмрөгөөс шүүрдэж үзлээ. Эрдэмтэд судлаачдын хэвлүүлсэн даатгалын үгсээс “Үрийн хайрханд даатгах даатгал” –д:

Алтан сайхан үрийн минь
Амин насыг аргамжиж хайрла
...Малгай мэтээр мана
Сүүдэр мэтээр дага
Энэ яваа насанд нь
Эх болж яваагийн хувьд
Хан гэх ханиадны нүүргүй
Тон гэх томууны нүүргүй
Арван цагаан буяны нь
Арван зүгт нь
Буман нарны гэрэл мэт

Дэлгэрүүлэн соёрхож хайрла (Rintchen, 1975:102) хэмээн өгүүлж байгаа ч судлаачид үүнийг бөөгийн аман яруу найрагт хамааруулж үзсэн байна. Миний бодлоор энэ даатгалын шүлэг нь ардын аман зохиолоос бөөгийн яруу найрагт орсон, хоорондоо шилжин хэрэглэгддэг ч байж болох юм.

Соёрхол. “Мялаалгын дараа шинэ хүнээ ахан дүүст нь золгуулна аа. Бүстэй хүүхдийг гал зөв, бүсгүй хүүхдийг гал буруу тойруулж, гар дамжуулж золгуулна аа. Шинэ хүнтэй хар гараар золгохгүй ээ, ариулж даллага авсан сахиус наадмаа барьж золгоно оо. Сахиус наадмаараа сайн хувь зохиолыг хамт соёрхно оо, заяан тэнгэр соёрхов гэнэ ээ. Манай талаас сийлбэр их өгнө өө, чоно өгвөл аз хийморь соёрхно оо, буга өгвөл урт нас соёрхно оо, унага өгвөл унааны тэнгэрийг ерөөнө өө. Есөн нүх заавал өгнө өө, төрд ивээгднээ, сайн алдар, цэцэн ухаан соёрхно оо, тээнгэ их өгнө өө, унаж бэртэхээс хамгаална аа, за тэгээд их цөс зориг, эрүүл бие, сайхан зүс байж болно оо, өмсөх эдлэх хувь, их хүү сан байж болно оо. Дархан хүн бол гарын ураа өгч болно оо, хүүхэн хүнд үйлэнд уран гэж соёрхно оо, аль сайныг л соёрхно оо. Соёрхлоо бэлгэтэй үгсээр хэлнэ ээ. Сайхан хэлдэг нь байна аа. Тулсан авга нагац нь халуун хошуут мал зүсэлж өгнө өө. Хүү бол бол унага даага зүсэлнэ ээ, битүү туурайтай юм заавал өгнө өө. Хүүхэн бол охин бяруу зүсэлнэ ээ, саальтай яв гэжийна аа. Зүсэлсэн малыг онд нь өгнө өө, сар шинээс наана хүргэж өгнө өө. Шинэ хүн галаа эргэж бүгдэд золгоод, соёрхол тосоод, эцэг эхдээ ирнэ ээ. Эцэг нь хүүгээ төрд нүүртэй болог гэвэл есөн нүх, бэл бэлдэнэ ээ, нарийн сураар сахиус наадгайг хэлхэнэ ээ, эрхий ороох сур болно оо. Эх нь хөх ногоон утсаар өлзий зангидаж, амин насыг бөхөлнө өө. Улаан утсаар ч байх л. Сахиус наадгайнуудыг буян хишгийн чагтага тосгуулж, гэрийн зүүн унинаас зүүнэ. Шаантыг мөлжөөд шагайг өлгийн бүснээс зүүнэ ээ, чөмгийг хатавчинд хавчуулна аа. Хүү бол морь шагай, хүүхэн бол гүү шагай зүүнэ ээ. Баруун шаантаас морь шагай, зүүн шаантаас гүү шагай гарна аа. Шаантны шагай

дөрвөн хошуу малын буяныг насад /насан турш/ дагуулнаа. Угаалга дуусаад багахан найрлана аа, найрын дараа багачуулыг барилдуулж, шилбүүр уралдуулаад шагнаана аа, гол нь багачуул баярлуулна аа. Хуучинд ноён баян хүн хүүгийн угаалга хийнээ гэдэг нь олныг найрлуулна аа...”⁹. Энэ хууч ярианаас шинэ төрсөн хүнийг тэнгэр дээдэст таниулж, тэднээс шинэ хүнд сайн хувь заяаг соёрхож байгааг авга нагац нар нь сахиус наадгайгаар дамжуулж байгаа гэсэн санаа байна. Хүүхдэд сайн хувь заяаг соёрхох үгсийн тухайд дараах цөөн хэдхэн жишээнээс үзэхэд зарим нь бидний мэдэх бэлгэ дэмбэрлийн үгс юм уу, мялаалгын үгс байна. Жишээлбэл: Хүүхдэд унага зүсэлж өгөхдөө:

Үр ачаар өнөр болоорой

Үрээ даагаар баян болоорой

Хүүхдийн сахиус наадгайд буга сийлж өгөхдөө:

Загал бугыг янзага байхад

Заяасан тэнгэр

Урт настай, удаан жаргалтай болоорой

Хүүхдийн сахиус наадгайд “есөн нүх” зүүж өгөхдөө:

Төрд нэртэй

Түмэнд нүүртэй яваарай

Хан тэнгэрт хайрлагдах болтугай

Шинэ хүүхдийн сахиус наадгайд тээнгэ өгөхдөө:

Хөвгүүн үр нь хөдөө дүүртүгэй

Хүүхэн үр нь нутаг зохитугай

Шинэ хүүхдэд баривч хийж ирсэн бол өгөхдөө:

Дотоод хормойг нь тос өөх мялаа

Гадаад хормойг нь ганзага сур чимэг

Эд нь хэврэг, эзэн нь мөнх болоорой.

Эдгээр сахиус наадгай нь дор бүрдээ аль нэгэн тэнгэр бурхан, онгод зэрэг ямар нэгэн хийсвэр ертөнцийн ээл ивээлийг төлөөлсөн бэлгэдэлтэй бөгөөд нарийн сураар хэлхэн зүүж, бэлгэдлийн чуулган бүтээснээр хүүхдийг сахин хамгаалж байдаг гэж итгэдэг байна. Сахиус наадгайн зүйлд есөн нүх, тэнгэрийн сум, бяцхан хонх, өлзий зангиа, тээнгэ, загасан нуруу, эр эм явуу, хушга, гахайн соёо болон чоно, буга, үнэг, адуу зэрэг амьтдын жижиг сийлбэр, бэл, гуулин зоос, жижиг нум сум, цоож зэрэг зүйлс байна. Монголчууд нүдэнд үл үзэгдэх хийсвэр ойлголт болох тэнгэр нарынхаа дүрийг дүрслэхдээ сүлд амьтны дүрсээс эхлээд тодорхой хээ дүрсээр бэлгэдэн төлөөлүүлж ирсэн нь эндээс харагдаж байна (Нандинбилиг 2010:142). Энэ заншил нь нялхсыг хөлд орох үед баривчинд явуу, тээнгэ хадаж, бойтгоос нь жижигхэн хонх зүүж, бүсний бэлээс нь элдэв бэлгэдэлт наадгайг зүүдэг уламжлалаар үргэлжилнэ.

⁹ Лханаагийн Сосор, 75 настай, морь жилтэй, тайж нарын бэр. 1992 оны 12 сарын 10-нд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын төвд Г.Нандинбилиг тэмдэглэж авав

Сахиус наадгайн бэлгэдлийг хүснэгтээр үзүүлбэл¹⁰:

Сахиус наадгайн зүйлс	Бэлгэдэл	Хандаж буй хийсвэр ертөнц	Дом
Эсгий үнэг		Ад элиэ	Ад элиэг эндүүрүүлэх дом
Бэл	Төрийн хар хүн	Төрийн сүлд	
Есөн нүх	9 тоо	Мөнх тэнгэр	Таниулах дом
Онгин ба дөрвөлжин тээнгийг эрэгтэй хүүхдэд	Газар нутгийн эзэн суух	Наран тэнгэр	Гэмтэх бэртэхээс хамгаалах дом
Саран ба гурвалжин тээнгийг эмэгтэй хүүхдэд	Нутаг ус	Саран тэнгэр	
Гуулин зоос	Бэл бэнчин	Эдийн тэнгэр	Эд баялаг дуудах дом
Өлзий зангиа	Ам бүлийн бат холбоо	Ургийн тэнгэр	Амь насыг зангидах
Загасан нуруу	Нурууг бэлгэдэх	Лус	Усны аюулаас хамгаалах
Эр эм явуу	Цэвэр ариуныг		Энхэр хүүхдийг хамгаалах
Хушга	Эр бэлгийг	Эцгийн тэнгэр	Удам залгах дом
Гахайн соёо, голхи	Газар нутаг гуйх	Газар эх, \Лус савдаг\	Лус савдгийн хорлолоос хамгаалах дом
Жижиг цоож	Амь насыг бөхлөх	Заяагч	Ороодог хүүхдийг тогтоох
Жижиг нум сум	Мэргэн харваач болохыг	Ангийн тэнгэр	Муу юмыг айлгах дарлагын дом
Чоно сийлбэр	Сүлд хийморийг	Чоно тотем	Аз хийморьтой явах
Буга сийлбэр	Урт насыг	Буга тотем	Урт наслах
Унага сийлбэр	Хүлэг унааг	Унааны тэнгэр	Унаатай явах
Эрхий ороох сур	Адуу малтай болох	Адуу малын тэнгэр	Олон малтай болох

Найр. Өмнө өгүүлсэн хууч ярианаас үзэхэд хүүхдийн ухиялын халх уламжлалд, хүүхдэд сайн хувь заяа соёрхож даатгах ёслолын дараа багахан найрладаг байсан тухай мэдээлж байна. Олны мэдэхээр хүүхдийн угаалгад архи дарс хэрэглэдэггүй, зарим нь бүр мах шүүс ч оруулдаггүй ёс байдаг.

Наадам. Найрын дараа хүүхэд барилдуулж, даага/шилбүүр уралдуулж наадам хийдэг байсан тухай мэдээлж байна. Харин буриад уламжлалд хүүхдийг хөөдсөний дараа, ихэсийг (хэгээг) цагаан бөсөөр ороож, эсгий уутанд хийгээд газар дор шингээж, хөх чулуугаар дарахын өмнө “...тостой хөөг хуруугаар өлгөж аваад нүүр нүүрээ тарлан эрээн болтол хөөдөлцөх домтой. Сүүлд нь юмыг зайлуулан цэвэрлээд, ширдэг дэвсээд хоёр залууг барилдуулна” гэж мэдээлсэн байна. Энэ хоёр уламжлалыг харьцуулж үзэхэд аль алинд нь наадмын утга санаа байгаа нь хүүхдийн угаалгын ёслолын дараа наадам хийдэг заншил лавтай байсныг илтгэж байна. Үүгээрээ хүүхдийн овооны тахилгын наадамтай төсөөтэй байна.

Шинэ төрсөн хүүхдийг ухиях ёслолыг өвлөн уламжлуулсан настны хэлж таниулсан аман хууч ярианы дээрх мэдээллийг задлан шинжилж үзэхэд энэ ёслол нь заллага, ариулга, сан, сацал, даллага, хурайлга, мялаалга, соёрхол, даатгал, залбирал, найр, наадам гэсэн хэсгүүдээс бүрдэж байна. Эдгээрийг зан үйлийнх нь үүрэг зорилгоор дахин ангилбаас “мялаалга”, “ухиал”, “даатгал” (“соёрхол”) гэсэн цуврал гурван зан үйл болж байна. Эхний зан үйл нь монголчууд аливаа шинэ эд зүйлсийг мялаадаг ёсоор хүүхдийн өлгийг мялааж байгаа зан үйл байгаа боловч энэ нь сан, ариулга, сацал, даллага, хурайлга гээд олон цогцолбор зан үйлийн

¹⁰ Nandinbilig G (2012). Rituals of Mongol Games and Worship of the Spirit masters of Heaven, Earth and Water.- Travaux de Symposium International le livre. La roumanie. L europe. Troisieme edition. 20-24 Septembre 2010. TOME III. La trouisieme section- ETUDES EURO-ET AFRO-ASIATIQUES. Editeur Bibliotheque de Bucarest, 2011, p 682-690

нэг хэсэг болохыг мэдээлж буйгаараа сонирхолтой байна. Хоёр дахь зан үйл нь хүүхдийг ухияаж, нэр өгч байгаа энэ зан үйлийн үндсэн хэсэг нь байна. Гурав дахь зан үйлийн тухайд хүний ертөнцөөс хийсвэр хүчинд хандсан харилцаа талаас авч нэрлэвэл “даатгал” гэж нэрлэж болно. Бас шинэ төрсөн хүнийг тэнгэр дээдэст таниулж, тэднээс хувь зохиол соёрхож байгааг авга нагац нар нь дамжуулж байгаа зан үйлийн харилцааг сахиус наадгайгаар тэмдэглэж байна гэж үзвэл “соёрхол” гэж нэрлүүштэй санагдана.

Хэрвээ нялхсын угаалгын ёслолыг нэгэн зан үйлийн жүжиг наадам гэж үзэх юм бол хүүхэд төрж мэндэлсэн нь үйл явдлын угтал шалтгаан болдгоороо эхлэл болж, тэнгэрт сацал өргөх, сан ариулж, даллага авах зэрэг нь зан үйлийн зангилаа болж байна. Харин хүүхдэд өлгий төхөөрөх, хурим нэрт идээг дээжлэн мялаах, хүүхдийг хонины шаантын шөлөөр угаах зэрэг нь өрнөл, хүүхдэд нэр хайрлаж, магнайг тэмдэглэх буюу хүүхдийг тэнгэрт таниулан даатгах нь туйл, сахиус наадан зүүлгэн сайн хувь заяа соёрхох нь тайлал гэлтэй бөгөөд найрын болоод наадмын хэсэг нь тус зан үйлийн төгсгөл хэсэг шинжтэй байна.

Дүгнэлт

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд, боржгин халхын тайж нарын уламжлалд шинэ мэндэлсэн хүүхдийг угаах, нэр өгөх ёстой хамаатай “мялаалга”, “ухияал”, “даатгал” гэсэн цувраа гурван зан үйл байжээ.

1. “Мялаалга” гэдэг нь шинэ хүүхдэд өлгий төхөөрч ариулан мялаах, цагаан будаатай аарц бүхий “хурим” нэрт идээнийг бэлтгэж дээжлэх анхдагч зан үйл байна.

2. “Ухияал” гэдэг нь шинэ хүүхдэд зориулан авгын сүргээс төхөөрсөн хурган хонины шаантыг чанаж, шөлөөр хүүхдийг угаагаад, авга нь нэр хайрлаж, тэнгэрт таниулах хоёр дахь зан үйл байна.

3. “Даатгал” гэдэг нь шинээр мэндэлсэн хүүхдийг Заяан тэнгэр (Милаан тэнгэр), “Долоон өвгөн” одонд (өвөг дээдэст) таниулан даатгахад ах эгч, авга нагац нараар дамжуулан хүүхдэд урт насны хутаг болоод сайн хувь заяаг соёрхож, олон зүйл сахиус наадгайг бэлэглэх гурав дахь зан үйл байна.

4. Энэ бүх зан үйлийг авга талаас ёслох бөгөөд хүүхэд нагацын гал дээр төрсөн бол нагац нар нь энэ ёсыг гүйцээснээр хүүхэд нагацын ургийн овогт хамаардгаас үзэхэд хүүхдийн угаалгын ёслол нь шинэ хүүхдийг аль ургийн овогт хамаарахыг шийдвэрлэх үүрэгтэй ёслол байна.

Summary

In this article, we will study of ritual for naming infants of the Borjgin nobility “taij nar”, based on the oral tradition about familial rituals and ceremony “infant bathing” of the “taij nar” in the main bag (the smallest administrative unit of Mongolia) of the former Dalai Choinkhor Vang khoshuu of Sain Noyon Khan province - the current Zurkh bag of Galt sum, Khuvsgul province. This familial ceremony originates from its ancient times and it has changed significantly, some of the detail have been lost, but the original concept has been preserved. So the main rituals and symbols have been studied, some forgotten information has been learned from historical sources and earlier studied Buryat traditions, Mongolian children's cairn rituals and oral literature. The aim is to restore the literature works with examples of previously documented sutra of the big dipper (7 burhan) and the insurance and then the pray of the shaman.

Номзүй

- Боржигин хошууны товчоон. 2011. Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 20 жилийн ойд. Боржигины түүхийг үлэмжилсэн нийтлэл уран сайхны ойллого, Товчоолсон Р.Батжаргал, МН Технологи хэвлэх үйлдвэр. Чойр.
- Дамдинсүрэн Ц.** 1959. *Монгол уран зохиолын дээж зуун билиг оривой.* Уб.
- Дулам С.** 2002. *Монгол бэлгэдэл зүй. IY. Зүүд зөн совингийн бэлгэдэл зүй, Цагийн бэлгэдэл зүй.* Уб.
- Дулам С., Нандинбилиг Г.** 2007. *Монгол аман зохиолын онол. I.* МУИС. Уб.
- Манжигеев И.А.** 1978. *Бурятские шаманистические и дошаманистические термины.* М. “Наука”.
- Монгол ардын зан үйлийн аман зохиол. 1987. Эмхэтгэж хэвлэлд бэлтгэсэн Х.Сампилдэндэв. Улаанбаатар
- Нандинбилиг Г.** 2010. *Монгол тоглоомын соёл хийгээд тэнгэр, лус савдгийн шүтлэг.* Монгол судлал. ЭШБ. МУИС. МХСС. Боть XXXII. 139-143. Уб.
- Нандинбилиг Г.** 2019. *Монголчуудын “Хүүхдийн овоо”-ны тахилга, бэлгэдэл.* Аман зохиол судлал. ШУА. ХЗХ-ийн ЭШ-ний сэтгүүл. Tom XL. Fasc 13. Уб.
- Nandinbilig G.** 2012. *Rituals of Mongol Games and Worship of the Spirit masters of Heaven, Earth and Water.- Travaux de Symposium International le livre. La roumanie. L europe. Troisieme edition. 20-24 Septembre 2010. TOME III. La troisieme section- ETUDES EURO-ET AFRO-ASIATIQUES. Editeur Bibliotheque de Bucarest, 2011, p 682-690*
- Rintchen B.** 1975. *Les materiuaux pour l’etude du shamanisme Mongol, 3-Textes chamanistes Mongols, Otto harrassowitz-Wiesbaden*